

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээговь сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: nananbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2026.03.25 № 57
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Ч.СУГАРМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудад дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 4 байгууллагын санхүүгийн нийт зөрчил 94.7 сая төгрөг бөгөөд бидний тогтоосон 47.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, 94.7 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-

4226050259

ын 11 дүгээр зүйлийн 11.1, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,161,420.76	4,277,791.46
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	729,614.37	2,380,755.77
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	150,125.55	217,343.96
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	85,838.95	174,292.27
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	63,250	63,250
6	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	132,591.89	1,442,149.46
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,163,101.54	1,128,985.68
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,163,101.54	1,128,985.68
9	1.2.2.02 Биет хөрөнгө		1,025,542.71	991,824.34
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	137,558.83	137,161.33
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		2,324,522.31	5,406,777.14
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		100,201.84	36,561.99
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		100,201.84	36,561.99
14	2.1.1.03 Өглөг		100,201.84	36,561.99
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,224,320.46	5,370,215.15
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		2,224,320.46	5,370,215.15
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		643,941.27	643,941.27
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		812,920.39	3,958,815.08
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		767,458.8	767,458.8
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		2,324,522.31	5,406,777.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		4,613,663.22	6,534,189.21
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		2,471,630.5	4,460,721.71
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		2,179,424.01	3,562,716.69

4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		2,245,845.23	3,562,716.69
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-66,421.22	0.0
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		227,344.67	291,109.2
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		64,861.82	606,895.82
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	478,785.51	2,073,467.5
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	1,070
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,663,247.21	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,709,554.24	3,378,770.35
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		4,709,554.24	3,378,770.35
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,194,623.44	2,496,417.95
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		715,429.85	965,027.02
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		84,416.25	115,005.4
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		514,413.37	598,013.04
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		2,002,159.43	231,813.55
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		43,581.63	39,391.93
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		15,352.7	15,100
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		84,142.74	74,580.92
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		735,127.47	457,486.09
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		514,930.81	882,352.4
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-95,891.03	3,155,418.86
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,833.02	590
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-1,833.02	-590
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		-97,724.05	3,154,828.86

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,261,661.85	6,318,789.64
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	2,471,630.5	4,460,721.71
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	2,179,424.01	3,562,716.69
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-66,421.22	0.0
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	227,344.67	291,109.2
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	64,861.82	606,895.82
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,985.5	47,484.35
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	41,876.32	559,411.47
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,784.14	1,858,067.93
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	126,784.14	68,612.43
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,070.0
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,788,385.5
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,663,247.21	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,297,485.85	2,979,496.72
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,297,485.85	2,979,496.72
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,692,146.01	2,059,140.38
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	730,964.89	963,669.86
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,472.76	116,663.34
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	514,413.37	598,013.04
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	41,036.47	39,693.78
21	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	82,058.53	58,260.93
22	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	15,352.7	15,100.0
23	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,564.16	91,913.32
24	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	105,283.13	175,826.11
25	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	605,339.84	920,356.34

26	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,964,176	3,339,292.93
27	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,962,383.48	1,587,561.53
28	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,962,383.48	1,587,561.53
29	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,962,383.48	1,587,561.53
30	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,962,383.48	-1,587,561.53
31	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	876.36	100,590.0
32	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-876.36	-100,590.0
33	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	916.17	1,651,141.4
34	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	728,698.2	729,614.37
35	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	729,614.37	2,380,755.77

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,324,540.39		2,324,540.39
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,495.88		-2,495.88
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,322,044.51		2,322,044.51
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-97,724.05		-97,724.05
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,224,320.46		2,224,320.46
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,224,320.46		2,224,320.46
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,934.17		-8,934.17
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,215,386.29		2,215,386.29
9	1.7 Тайлант үеийн үр дүн	3,154,828.86		3,154,828.86
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,370,215.15		5,370,215.15

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,823,782.9	6,312,494.64
2	3.1.01.1.1 Татварын орлого	2,943,355.2	4,460,721.71
21	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,880,427.7	1,851,772.93
29	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,432,418.2	4,583,641.93
30	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	3,177,164.3	2,893,414.98
31	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,201,561.5	1,973,058.64
32	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,033,645.5	963,669.86
37	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,293.3	116,663.34
43	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	617,140	598,013.04
47	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	47,850	39,693.78
53	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	82,000	64,134.93
57	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	21,080	15,100
59	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,052.7	91,913.32
66	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	128,500	83,870.38
69	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	975,602.8	920,356.34
75	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,107,396.5	1,589,636.95
77	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	147,857.4	100,590
79	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	608,635.3	1,728,852.71
80	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-608,635.3	-1,728,852.71
81	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-608,635.3	-1,728,852.71
82	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	608,635.36
83	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	2,337,488.07
84	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	60.0	52.0
87	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.0	25.0
88	6.2.01 Удирдах ажилтан	7.0	7.0
89	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	11.0	7.0
90	6.2.03 Үйлчлэх ажилтан	11.0	11.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,070.0
2	12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,070.0
3	122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	1,070.0
4	1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	1,070.0
5	12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	1,070.0
6	350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0
7	350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70.0
8	II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,344.0
9	21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,344.0
10	210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,344.0
11	2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	2,344.0
12	210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	2,344.0
13	4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-1,274.0
14	5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,274.0
015	6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,274.0
16	9	2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.4.1.1 ТТЗ-ийн тайланд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

4.4.1.2 Харьяа байгууллагууд

Харьяа төсвийн байгууллагуудад Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад нийт 151.8 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна.

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, гүйцэтгэл цэсэнд цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 17.4 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, бусад цэст хөрөнгө зарцуулахтай холбоотой 27.5 сая төгрөгийн 6 шийдвэр хугацаа хоцроож мэдээсэн /Шивээговь сумын ЗДТГ/
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 204.9 төгрөгийн 5 зарлагын гүйлгээ, 963.9 сая төгрөгийн 7 орлогын гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн, зөрчлийг давтан гаргасан /Шивээговь сумын ОНХС/
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 100.0 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 6.9 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээ хугацаа хоцорч мэдээлсэн /Шивээговь сумын ХХС/

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдсан, өмнөх оноос буураагүй, Шивээговь сумын ЗДТГ-ын 2025 оны төсвийн санхүүжилтийн орлого, зарлага, төвлөрүүлэх шилжүүлгийг бүртгэлийн дансны үлдэгдлийг баталгаагаар баталгаажуулаагүй, Шивээговь сумын ИТХ-ыг 6.0 сая төгрөгөөр зөрүүтэй баталгаажуулсан, хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив"-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3-д "орон нутгийн хөгжлийн сан, тусгай зориулалтын шилжүүлэг, сумын нэгдсэн төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын нягтлан бодогч болон төрийн сангийн мэргэжилтнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)", 1.1.10-д "харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хүлээн авч шалгах, залруулга хийх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх. (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор нэмсэн)" гэсэн заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл, тайлагналд хяналт тавих, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2.2 Харьяа байгууллагууд

Харьяа төсвийн байгууллагуудад бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илрээгүй байна.

5. Аудитын илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 265.8 сая төгрөгийн 4 алдаа илэрсэн бөгөөд аудитын явцад залруулга хийсэн байна.

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, 1.6 сая төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт, 2.1 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,706.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,451.8 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1.4 сая төгрөгийн 4 зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 243.8 сая төгрөгийн 7 зөрчилд 4 албан шаардлага, 9.6 сая төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 42.5%-аар өссөн ба үүнээс: залруулга 3.5 дахин, төлбөрийн акт 40% тус тус өссөн бол албан шаардлага 67.1%, зөвлөмж 76.1%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 98.4 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

5.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

5.1.1 Төлбөрийн акт

2023 оны сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Хүүхдийн тоглоомын талбай" ажлын магадлалгүй ажлын зардал 1.6 сая төгрөгийг хэмнэлтэд тооцоогүй, барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.6.12-т “магадалшгүй ажил гарсан бол оролцогч талуудын шийдвэрлэсэн хурлын тэмдэглэл”, 4.3.6.13-т, “магадалшгүй ажлын төсөв”, 4.3.6.14-д “магадалшгүй ажлын акт эх хувь”, 4.3.6.15-т “магадалшгүй ажлыг баталгаажуулсан баримт” дахь гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох, 2026.05.25-ны дотор төлбөрийн актыг барагдуулж хариу ирүүлэх

5.1.2 Албан шаардлага

Байхгүй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шивээговь сумын соёлын төвийн тогтмол зардлын санхүүжилтийг батлагдсан төсвөөс 2.1 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив"-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3-т "орон нутгийн хөгжлийн сан, тусгай зориулалтын шилжүүлэг, сумын нэгдсэн төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын нягтлан бодогч болон төрийн сангийн мэргэжилтнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)", 1.1.10-д " харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хүлээн авч шалгах, залруулга хийх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх. (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор нэмсэн)" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөв, хуваарийн дагуу санхүүжилт олгох, хяналт тавих зөвлөмж өгөх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шивээговь сумын Засаг дарга	4	265.8	-	-	4	265.8	4	265.8				
Шивээговь сумын ИТХ	1	2.8	1	2.8	-	-	1	2.8				
Шивээговь сумын ЗДТГ	2	4.7	1	4.3	1	0.4	2	4.7				
Шивээговь сумын ОНХС	1	1,442.1	1	1,442.1	-	-	1	1,442.1				
Шивээговь сумын ХХС	1	2.2	1	2.2	-	-	1	2.2				
Дүн	9	1,717.6	4	1,451.4	5	266.2	9	1,717.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шивээговь сумын Засаг дарга	2	3.7	1	1.6	-	-	1	2.1				
Шивээговь сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-				
Шивээговь сумын ЗДТГ	6	2.6	3	1.2	1	0.0	2	1.4				
Шивээговь сумын ОНХС	3	82.1	1	0.2	2	81.9	-	-				

Шивээговь сумын ХХС	1	10.0	-	-	1	10.0	-	-				
Нийт	12	98.4	5	3.0	4	91.9	3	3.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шивээговь сумын Засаг дарга	-	-						
Шивээговь сумын ИТХ	-	-						
Шивээговь сумын ЗДТГ	1	45.0			1	45.0		
Шивээговь сумын ОНХС	1	0.0			1	0.0		
Шивээговь сумын ХХС	1	106.8			1	106.8		
Дүн	3	151.8			3	151.8		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоогүй зөрчил								
Шивээговь сумын Засаг дарга	1	32.5			1	32.5		
Шивээговь сумын ИТХ								
Шивээговь сумын ЗДТГ								
Шивээговь сумын ОНХС								
Шивээговь сумын ХХС	1	8.3					1	8.3
Дүн	2	40.8			1	32.5	1	8.3
Нийт дүн	5	192.6			5	184.3	1	8.3

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	2			2			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	2		2					
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	5	3	2		2	1		

